



ASIAN-PACIFIC
CONGRESS on
EVANGELISM
SYDNEY 2027

Мэдээлэл хүргэх нь

**2027 ОНЫ 8-Р САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЗИ НОМХОН ДАЛАЙН
БҮС НУТГИЙН САЙНМЭДЭЭНИЙ ЧУУЛГА УУЛЗАЛТ**

Ази, Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээний ЧУУЛГА УУЛЗАЛТ 2027 оны 8-р сарын 24–26-ны өдрүүдэд Австралийн Сидней хотод зохион байгуулагдана.

Media contact: media@billygraham.org

СИДНЕЙ хот 2025.10.16: Австралиас Афганистан, Монголоос Малайз хүртэлх 50 гаруй улс орноос ирсэн 2,500 гаруй христ итгэлт удирдагчид ирэх хоёр жилийн хугацаанд Ази-Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээний чуулга уулзалт-ын хүрээнд Сидней хотноо цуглахаар төлөвлөгдсөн байна. Пасторууд, сайнмэдээ түгээгчид болон бүх насны үйлчлэлийн удирдагчид гурван өдрийн турш нэг дор цуглаж 10 гаруй хэл дээр урам зориг, сорилт бэрхшээлүүдээ хуваалцаж, Есүс Христийг мэдэхгүй олон тэрбум хүнд зоригтойгоор сайнмэдээ түгээх арга барилаар бэлтгэгдэнэ.

“1990-ээд оны эхээр Монгол улс ардчилсан нийгэм рүү шилжиж эхэлсэн үед улс даяар дөрөвхөн л Христийн дагалдагч байсан. Гэвч Сайнмэдээ тунхаглагдсанаар амьдралын жинхэнэ баяр хөөр, үнэ цэнэ болон Бурханы хайр Монгол даяар тархсан юм” хэмээн Улаанбаатар хот дахь Гэрэлт хот Христийн чуулганы пастор Т.Угтахбаяр онцоллоо.

“Бидний дараагийн үеийнхний дунд Сайнмэдээний гал дүрэлзэж байна. Энэхүү чуулга уулзалт нь Монгол төдийгүй Ази, Номхон далайн бүс нутагт Сайнмэдээний галыг асаах түлш болно гэдэгт итгэж байна. Энэ цаг бол бид хамтдаа Ази, Номхон далайн ургацын талбайруу ажилчдыг илгээхийн төлөө Эзэнээс гуйн залбирах цаг мөнөөс мөн.

БГСМХ (Билли Грейамын Сайнмэдээний холбоо)-ны ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал бөгөөд уг чуулга уулзалтыг санаачлагч Франклин Грейам: “Энэ бол Ази, Номхон далайн бүс нутаг дахь Христийн чуулгануудын хувьд чухал шийдвэрлэх мөч юм. Бид дараагийн үеийн Христэд итгэгчдийн зүрх сэтгэлд ариун галыг асааж, тэднийг итгэлийн бамбарын гэрлийг алслагдан тусгаарлагдсан хүн ам бүхий арал, тосгон болон хот бүрд хүрээсэй гэж хүсэж байна. Есүс Христийн сайнмэдээг дэлхийн зах хязгаар хүртэл айдсаар бус, итгэлээр тунхаглах итгэгчдийг зоригжуулан урамшуулах нь бидний хувьд нэр төрийн хэрэг юм.”

Берлин дэхь чуулга уулзалтын суурь

БГСМХ-ны анхны Дэлхийн Сайнмэдээний чуулга уулзалт 1966 онд Германы Берлин хотод зохион байгуулагдаж байв. Үүний дараа уг чуулга уулзалт 1983, 1986, 2000 онуудад Амстердам хотноо үргэлжлэн зохион байгуулагдсан байна.

Энэхүү уламжлалыг үргэлжлүүлэн 2025 оны тавдугаар сард Берлин хотноо болсон Европын Сайнмэдээний чуулга уулзалтын дараагаар Ази Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээний чуулга уулзалт зохион байгуулагдах юм. Тус Берлиний чуулга уулзалтад Европын 55 орноос 1,000 гаруй удирдагчид нэг дор цуглаж, айдасгүйгээр Сайнмэдээг тунхаглах амлалтаа эргэн сэргээн санасан юм. Олон оролцогчид зүрхэндээ галыг бадраан Эзэний загалмайн найдварыг түгээхээр буцсан.

Италийн нэгэн пастор чуулга уулзалтын дараа нутаг буцаж урдынхаасаа ч илүү залбирал, зориулалттайгаар сэтгэл зүрхээ зориулан үйлчлэхээр шийдвэр гаргасан байна. Тэрээр залуучуудын зуны кемп зохион байгуулж, тус үйлчлэлээр нь дамжуулан 40 залуу Есүс Христэд итгэж, Түүнд амьдралаа даатгасан байна.

Пастор Дэнни Паскуале хэлэхдээ - “Чуулга уулзалтад оролцсоныхоо дараа би хүмүүст Сайнмэдээг хүлээн авах боломж олгох, тэднийг шийдвэр гаргах хүртэл тууштай уриалах нь чухал болохыг илүү ойлгосон. Мөн залбиралд зориулалт гаргаж, Эзэний Сайнмэдээ тэдгээр залуучуудын амьдралд бодитой нөлөөлөхийн төлөө залбирсан юм.”

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГТ САЙНМЭДЭЭНИЙ ГАЛЫГ АСААХ НЬ

Тус бүс нутагт нийтдээ 4 тэрбум гаруй хүн амьдарч байгаа бөгөөд тэдний 10 хүрэхгүй хувь нь Христэд итгэгчид юм.

Европын Сайнмэдээний чуулга уулзалтад илтгэл тавьсан Сидней хот дахь Англикан чуулганы архибишоп Канишка Раффел хэлэхдээ: “Берлиний чуулга бидэнд нэгэн нэгдмэл дүр зургийг үлдээсэн нь Сайнмэдээг зоригтой бөгөөд тодорхой тунхаглацгаая гэсэн алсын хараа байлаа. Ази, Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээ тунхаглагчид Австралид цуглан, 'Христийг тунхаглах' гэсэн нэгэн зорилго, нэгэн дуудлагын дор нэгдэх гэж байна. Энэ бол Австрали болон Ази Номхон далайн бүс нутагт өгөгдсөн гайхалтай, алдаж болохгүй боломж билээ.”

Уг Ази Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээний чуулга уулзалтад зөвхөн урилгаар оролцох боломжтой бөгөөд итгэгч та бүхнийг уг чуулга уулзалтын төлөө залбирч эхлэхийг уриалж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ирэх саруудад олон нийтэд хүргэх болно.

ЧУУЛГАНЫ УДИРДАГЧДЫН ЭШЛЭЛЭЭС:

- **СИНГАПУР | Пастор Эдмунд Чан, Олон улсын дагалдагч бэлтгэх чуулганы холбооны үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн дарга**

“Сайнмэдээгүй дагалдуулалт гэдэг сохроос өөрцгүй. Дагалдуулалтгүй Сайнмэдээ нь доголлонгоос өөрцгүй. Тиймээс би 2027 онд Австралийн Сидней хотод болох Ази Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээний чуулга уулзалтын төлөө маш их догдолж байна. Энэ газар Сайнмэдээний хэрэгцээ асар их байгаа. Нэг авралын дор буй бид бүгд Бурханы алдрын төлөө - зарим нь үрээ суулгаж, зарим нь усалж, зарим нь хураах өөр өөрсдийн үүргээ сайн сахин биелүүлж чадна гэдэгт итгэлтэй байна! (1 Кор. 3:5–9)”

- **ФИЛИППИН | Бишоп Эфраим М. Тендеро, Дэлхийн Эвангелийн Эвслийн олон улсын элч, Галилей хөдөлгөөний гүйцэтгэх захирал**

“Дэлхийн хүн амын дийлэнх хувь нь амьдарч буй болон хамгийн их Христийг хараахан танихгүй хүмүүс оршин суугаа уг бүс нутагт Христэд итгэгчдийг бэлтгэж, хүчирхэгжүүлж, идэвхжүүлэх нэн тэргүүний шаардлагыг бид бүгд мэднэ. Бид энэхүү сорилтыг хамтдаа даван туулж, шинэ үеийн Христийн дагалдагч, Түүндэй адил ургац хураагч болон сайнмэдээ тунхаглагч нарыг хүчирхэгжүүлэн хөдөлгөж, Ази Номхон далайн бүс нутгийг Христийн төлөө өөрчлөх болно.”

- **МАЛАЙЗ | Др. Даниел Хо, Даманзара Утама Методист чуулганы үүсгэн байгуулагч, тэргүүн пастор**

“Христийн хүсэл болох алдагдсан нэгнийг хайж, аврах даалгавар бол бидний хамгийн чухал зорилт байх ёстой. Дэлхийн сүм чуулгануудын өсөлт удааширч, олон амийг Христгүй мөнхийн үхэлд алдаж буй энэхүү адармаатай цаг үед үүнээс илүү чухал зүйл үгүй билээ. Энэ бол чуулгануудын хувьд ахин босож, зөвхөн Есүс Христээр дамжин олдох цорын ганц найдварыг тунхаглах цаг мөч юм”

- **ЛАОС | Рев. Др. Камденг Коунтапаняа, Лаосын Эвангелийн Чуулганы Гүйцэтгэх Ерөнхийлөгч**

“Ази, Номхон далайн бүс нутаг нь 4 тэрбум гаруй хүмүүсийн гэр орон бөгөөд дэлхийн нийт хүн амын талаас илүү нь оршин суудаг. Итгэл үнэмшил, шашины хувьд ч олон төрлийн ялгаатай байдгаараа онцлогтой. Энэ нутаг нь Есүс Христийн үнэн болсон Сайнмэдээг тунхаглах томоохон ургацын талбай адил билээ. Ази, Номхон далайн орнуудын Сайнмэдээний Чуулга Уулзалт нь энэ бүс нутагт амьдардаг итгэгчдийг хамтад нь нэгтгэн, сайнмэдээг тунхаглах шаардлага өндөр байгааг дахин нэг сануулсан онцгой цаг байх болно.”

- **КАМБОЖ | Рев. Хэн Ченг, Камбожийн Сайнмэдээний Холбооны удирдагч**

“Ази Номхон далайн бүс нутгийн Сайнмэдээний чуулга уулзалт нь Камбож улс болоод тус бүс нутгийн хувьд чухал мөчийг авчирч байна. Энэ нь итгэгчдийг Сайнмэдээг үг ба үйлдлээр хамтдаа түгээхэд урам зориг өгөх, бэлтгэх зорилготой юм. Сайнмэдээ нь Христийг гэрчлэгч гэр бүлүүд болоод тэдний өдөр тутмын харилцаанаас бусад хүмүүс шинэ амьдралын баяр хөөрийг олж харахаас эхэлдэг билээ. Уг чуулга уулзалт нь Сайнмэдээг түгээн, дагалдагчдыг бий болгох үйлсийг нэгэн зэрэг хэрэгжүүлэхийг сануулж, бүх итгэгчдийг Есүсийн талаарх мэдээг цоо шинэ хүсэл тэмүүлэл болоод нэгдмэл байдлаар амьдруулахыг уриалж байна.”

- **ИНДОНЕЗ | Рев. Чарльз Жонан, Гэрэг Бетель чуулганы Маркет Плейс салбарын удирдагч**

“Есүс Иохан 4:35-д хэлэхдээ: ‘Та нар “Ургац хураалт болтол дөрвөн сар байна” гэж хэлдэг биш үү? Үзэгтүн, Би та нарт хэлье. Хараагаа дээшлүүлж, талбайг харагтун. Учир нь талбай цайрч, хураалтад бэлэн болжээ.’ Бүгдээрэй нэгдэн цуглаж зүрх сэтгэлээ нэгтгэн, Ази Номхон далайн бүс нутагт арвин их сүнслэг ургац хураах ажилд хамтдаа шамдацгаая. Ургац нь арвин, ажилчид нь цөөн юм.”

- **ШИНЭ ЗЕЛАНД | Др. Роберт Сиакимоту, “Open Air Campaigners, Polynesian Ministries”-ийн хамтран үүсгэн байгуулагч**

“Ази Номхон далайн бүсэд сайнмэдээ түгээгчдийн үйлчлэл болоод Сайнмэдээний хэрэгцээг хүлээн зөвшөөрөх цаг аль хэдийн болсон. Өмнөд номхон далайн орнуудад үйлчилдэг Шинэ Зеландын сайнмэдээ түгээгчийн хувьд энэхүү чуулга уулзалт нь олон сайнмэдээ түгээгчид болоод чуулгануудыг айдасгүйгээр Сайнмэдээ тунхаглах, илүү олон Христэд итгэгчийг бэлтгэх урам зориг өгөх болно гэж итгэж байна.”

- **СОЛОНГОС | Др. Билли Ким, Far East Broadcasting Company-ийн дарга, 1973 оны Сөүл дэх Билли Грейамын сүүлчийн айлчлалын орчуулагч**

“Өнөөдөр Солонгос болон Ази Номхон далайн бүс нутагт Сайнмэдээний хэрэгцээ урьд өмнөхөөс илүү шаардлагатай болоод байгаа билээ. Секулярчлал нэмэгдэж, сүнслэг өлсгөлөн гүнзгийрч байгаа энэ үед бид зоригтой, энэрэнгүй бөгөөд даруугаар Сайнмэдээг тунхаглах үүрэгтэй. Миний хувьд онцгойлон залуу пасторуудыг итгэл, урам зоригтойгоор ирээдүй рүү тэмүүлэхийг үйлчлэхийг уриалж байна. Энэхүү цугларалт нь сэргэлт, нэгдмэл байдал болоод Агуу захирамжийг биелүүлэх шинэ хүсэл эрмэлзлийг бий болгох хүчтэй түлхэц болох болтугай.”

- **ХОНГ КОНГ | Рев. Эрик Тонг, Хонг Конгийн Баптист чуулганы ерөнхийлөгч**

“Бурхан Ази Номхон далайн бүсэд хүчтэй ажлаа хийж байна. Энэхүү Сайнмэдээний чуулга уулзалт нь үүний баталгаа юм. Энэ бол зөвхөн арга хэмжээ бус, итгэгчдийг нэгтгэх, итгэлээ сэргээх, шинэ удирдагчдыг Есүс Христийн нэрийг зоригтой тунхаглахад бэлтгэх стратегийн алхам юм. Сэргэн мандлын шинэ давлагаа ирж байна, уг чуулга уулзалт нь үүний түлхэц болох болно. ‘Үзэгтүн, Би шинэ зүйл хийх бөгөөд Тэр нь одоо соёолж гарна. Та нар үүнийг мэдэхгүй гэж үү?’ (Исаиа 43:19)”

- **ТАЙЛАНД | Др. Верадед Житсакданонт, Тайландын Сайнмэдээний Хороо, Тайландын Протестант чуулгануудын зохицуулах хорооны дарга**

“Тайландын чуулгануудын хувьд бид улс даяар Бурханы хайрын үнэнээр Түүний хаанчлалыг тэлэх нэгдсэн үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа бөгөөд БГСМХ нь Сайнмэдээг тунхаглах нэн шаардлагатай хэрэгцээг онцлон энэхүү Ази Номхон далайн сайнмэдээний чуулга уулзалтыг зохион байгуулж буйд баяртай байна. Энэ нь чуулгануудын нэгдмэл байдлыг харуулах, ‘Бүх ертөнцөөр явж, сайнмэдээг хамаг бүтээлд тунхаглагтун.’ (Марка 16:15) гэсэн бидний үүргийг нэгтгэх чухал цугларалт болох юм.”

- **ВЬЕТНАМ | Рев. Хо Тан Кхоа, Вьетнамын Сайнмэдээний Холбооны ерөнхийлөгч**

“Сүүлийн жилүүдэд Вьетнам чуулганууд олон хотуудад сайнмэдээний хөтөлбөрүүдийг амжилттай зохион байгуулан Сайнмэдээг түгээсээр байгаа билээ. Энэхүү чуулга уулзалт нь чуулгануудыг цаашид бэлтгэх, Ази Номхон далайн бүс нутгийн бүх итгэгчдийг Есүс Христийн Сайнмэдээг ичилгүйгээр тунхаглахыг сануулах болно.”

- **ЯПОН | Рев. Ёшиказу Такада, Шинэ Зеландын Христийн чуулганы, Ниппон Осака салбар чуулганы тэргүүн пастор, Японы Сайнмэдээний Төвийн дарга**

“Хөшиг хураагдах цаг нь иржээ. Японд 125 сая хүн амьдарч, олон янзын хиймэл шүтээнүүдэд мөргөдөг. Харин мөнхийн амьдралын зам болох үнэн Бурхан Японы ард түмнээс хэдэн зуун жилийн турш нуугдсаар байна. Гэвч Иохан 14:6-д Есүс, ‘Зам, үнэн, амь бол Би байгаа юм. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй’ гэж айлдсан. Бурханы Үг Ариун Сүнсний хүчээр тунхаглагдах үед хөшиг хураагдаж, Түүний алдар илчлэгдэх болно. Энэ үнэн Япон болон Ази, Номхон далайн бүс нутагт Бурханы ивээлийн хур бороо мэт асгарч бууна гэж би залбирч байна. Бид үүнд агуу итгэл, найдвартайгаар бэлтгэн хүлээж байна.”

Төгсөв.

РЕДАКТОРУУДАД

МЭДЭЭЛЛИЙН БОЛОМЖУУД:

- Хэвлэл, нийтлэлд зориулсан зураг, бичлэгийн эхүүд: Media.BillyGraham.org/Asian-Pacific-Congress-on-Evangelism.
- Сэтгүүлчдийг тус чуулга уулзалтад оролцох бүртгэлээ хийхийг урьж байна. Чуулган нь Австралийн Шинэ Өмнөд Уэльс мужийн Сидней хотын **International Convention Centre Sydney (ICC Sydney)**–д, **14 Darling Drive, Sydney NSW 2000** хаяг дээр зохион байгуулагдана.
- Сэтгүүлчдэд бүртгэлийн хураамж үнэгүй төлбөргүй бөгөөд чуулганы үеэрх хоол хүнсийг мөн үнэгүйгээр үйлчлэх болно.
- Бүртгүүлэх эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд дараах хаягаар холбогдоно уу: media@billygraham.org.

БИЛЛИ ГРЕЙАМЫН САЙНМЭДЭЭНИЙ ХОЛБООНЫ ТУХАЙ

1950 онд ноён Билли Грейамын үүсгэн байгуулсан Билли Грейамын Сайнмэдээний холбоо нь Есүс Христийн сайн мэдээг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага юм. АНУ-ын Хойд Каролина мужийн Шарлотт хотод төвтэй тус байгууллага нь дотоодын болон олон улсын өргөн хүрээ бүхий үйлчлэлийг удирддаг. Тэдний үйлчлэлд: Франклин Грейам болон Уилл Грейам нарын удирддаг том хэмжээний сайнмэдээний конперенцүүд, Билли Грейамын номын сан, 24/7 Билли Грейамын залбиралын утас, Хойд Каролинагийн Эшвилл хотын ойролцоо байрлах Билли Грейамын сургалтын төв “The Cove”, мөн хэвлэл, телевиз, утас, радио болон интернэтээр дамжуулан олон хүнд хүрч үйлчилдэг ажээ.

Билли Грейамын Түргэн Хариу Үзүүлэх Багийн (Rapid Response Team) Гамшгийн сургалттай үйлчлэлийн багынхан. Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад 40 гаруй удаа ажиллан, гамшигт нэрвэгдсэн хүмүүст сэтгэл санааны болон сүнслэг дэмжлэг үзүүлсэн байдаг. Үүнд 2011 оны Японы Сендай хотын газар хөдлөлт, 2014 оны Филиппиний Себү хотын хар салхи, 2022 оны БНСУ-ын Сөүлийн Хэллоуины эмгэнэлт шахцалдааны үеийн тусламжууд орно. БГСМХ-ны интернэт сайнмэдээний төсөл болох SearchforJesus.net нь дэлхий даяар 100 сая гаруй хүнд хүрсэн бөгөөд жил бүр Ази, Номхон далайн бүсийн олон зуун мянган хүнд сайн мэдээг хүргэсээр байна. Дэлгэрэнгүй мэдээллийг billygraham.org хаягаар орж үзнэ үү.